



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/08

Баян-Өндөр сум

**Ээлжит хуралдаан
зарлах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэг, 46.6 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 07 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журам”-ын 4.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 02/11 дүгээр тогтоолоор батлагдсан Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэгийн 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дэх удаагийн сонгуулийн Ээлжит VI хуралдааныг 2026 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр танхим цахим хосолсон хэлбэрээр зарлан хуралдуулж, дараах асуудлыг хэлэлцүүлэхээр тогтоосугай. Үүнд:

- 1.1. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны хэрэгжилтийн тухай;
- 1.2. Аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай;
- 1.3. Орхон аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тухай;

2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит VI хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Зөвлөлийн гишүүдэд даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
даргын 2026 оны 01 дүгээр сарын 21-ний
өдрийн А/08 дугаар захирамжийн хавсралт

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ VI ХУРАЛДААНЫ БЭЛТГЭЛ ХАНГАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит VI хуралдааныг зарласан тухай мэдээллээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдийг хангах;

1/21-ний дотор

Ажлын алба

2.“Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны хэрэгжилтийн тухай” асуудлын илтгэл, биелэлтийн тайлан, тогтоолын төслийг боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

1/21, 1/26, 1/29-ний дотор

Аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр

3.“Аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай” асуудлын илтгэл, холбогдох биелэлтийг гаргаж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

1/21, 1/26, 1/29-ний дотор

Аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр

4.“Орхон аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тухай” асуудлын илтгэл, холбогдох биелэлтийг гаргаж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

1/21, 1/26, 1/29-ний дотор

Аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр

5.Хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан холбогдох Хороод ажиллаж санал дүгнэлт гаргах;

1/26-28-ны дотор

Холбогдох Хороод

6.Техник зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангах;

1/29-ний дотор

Ажлын албаны дарга Ш.Ганболд